

Та хоёр долоо хоног тутам эмнэлэгт үзүүлж байх хэрэгтэй. Хэрвээ хvvхэд тань энэ вед торвол амьдрах боломжтой. Харин маш нарийн асаргаа шаардах болно.

Санамж:

- Жирэмсний зарим зовиурууд илэрнэ. Эдгээр нь торсний дараа арилдаг. Гэдэс ходоодны хямрал илэрч байвал бага багаар ойр ойрхон идэх нь зvйтэй ба хямрал vvcгэж байгаа хvнс хоолноос татгалзах нь зов.
- Энэ вед танд хамгийн хэрэгтэй зvйл бол амрах, унтах явдал юм. Гэдэс томорч, мон хvvхдийн ходолгоон нэмэгдсэнээс таны унтаж амрахад саадтай байх авч хэвтэж амрах ор дэвсгэрээ оортоо тохируулж засах нь тустай байх болно.
- Хуучин омсдог хувцаснууд тань багтахгvй учраас оор хувцас худалдаж авах эсвэл оортоо тохируулан хийж омсвол зохилтой. Ховон даавуугаар хийсэн хувцас холрохоос хамгаална.

Суллаж чангалдаг бvстэй байх нь зvгээр байдаг.

- Тохиромжтой байрлал Энэхvv байрлал нь хэвтэхэд их амар байдаг.
- Хэрвээ удаан зогссоноос хол гараар тань хавагнасан бол холоо дээш оргон хэвт. Хаван буухгvй 24 цагаас дээш хугацаа болж улмаар гар, нvvр хавагнавал яаралтай эмчид хандаарай.
- Савны агшилт нэг цагт 5-аас дээш байвал эмчид үзүүл
- Гэдэс томрохын хирээр таны тэнцвэр алдагддаг тул унаж бэртэхээс ямагт болгоомжил
- Жирэмсэн veийн дасгал хийх, эрvvл агаарт зугаалах, амрахаа мартаж болохгvй

ЭХЭД гарах өөрчлөлт

- Хэвлий, гуяар арьс язарч болно
- Савны агшилтыг та мэдрэх болно
- Зvрхээр дэлсэх, ходоод гэдэсний хямрал илэрч болно
- Таны жин 7 хоногт 450 гр-аар нэмэгдэх болно

ТАНЫ ХҮҮХДЭД гарах өөрчлөлт

- хvvхдэд оохний хуримтлал эрчимтэй явагдана
- эрхий хуруугаа хохно, уйлна
- тийрэх, мушгирах зэргээр ходолно
- гэрэл, дуу авианд хариу vйлдэл vзvvлнэ
- урт нь 37 см, жин 900 г болжээ